# АГУУЛГА


**НЭГ.НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР 2-5

1.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР 5-9

1.3 СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР 9-27

1.4 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР 27-33

1.5 ДОТООД АЖЛЫН ТАЛААР 34-45

**ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТООН МЭДЭЭ, ТАЙЛАН**

2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 46-53

2.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД 54-55

2.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАЛТЫН ТАЛААР 56-60

**ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

3.1 ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР 61-63

3.2 ГАДААД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР 53-57

3.3 ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР 58-63

3.4 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР 64-66

3.5 БУСАД АЖЛЫН ТАЛААР 66-67

## НЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт Монгол Улсын Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, нийслэлийн иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай, чанартай, шуурхай үзүүлэх, нийслэлийн иргэд, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үндсэн зорилго, чиглэлтэй ажиллаж байна. Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нутаг дэвсгэрийн байршлаар Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд нийгмийн даатгалын хэлтэстэйгээр зохион байгуулагдан нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Тус газар нь 2021 онд Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Улсын Их Хурал, Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зорилт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрийн  биелэлтийг хангахад чиглэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд болон Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт, дээд газрын тогтоол шийдвэрийнбиелэлт, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын “Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт”-ийг тус тус гарган Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын харьяа хэлтсүүдэд   хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/01 тоот тушаалаар “Эерэг хандлага-цахим үйлчилгээний хөгжүүлэлтийн жил” болгон зарлаж нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дэд төлөвлөгөө боловсруулан ажил үйлчилгээгээ уялдуулан зохион байгуулан ажиллаж байна.

❖ Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын  сайдын  2020.12.30-ны №А/246/А/245 хамтарсан тушаал Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт, Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягтыг хөтлөх журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн  нийгмийн даатгалын цахим дэвтэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаныэмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар түр алдсаныэмнэлгийн хуудасны тооцоо,  жирэмсэн болон амаржсаныэмнэлгийн  хуудас,

тэтгэврийн хувийн хэрэг, сайн дурын гэрээ, шимтгэлийн НД7, НД8 маягт зэргийг батлагдсан маягтын дагуу үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар шинээр даатгуулсан даатгуулагчид журмын 2.1.1-д зааснаар QR код бүхий нийгмийн даатгалын цахим дэвтрийг батлагдсан Б-НД-1 маягтын дагуу олгож эхэлсэн.







❖ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 483-р тогтоолоор “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлсэн ба 2021 онд уг тогтоолын үргэлжлэн хэрэгжиж байна.Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд малчнаар **237**иргэний **704,847.8** мянган төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн **533** иргэний **883,843.4** мянган төгрөг, нийт **770** хүн хамруулж **1,468,015** мянган төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж тэтгэврийн даатгалын санд хуримтлуулсан байна.








❖ УИХ-ын чуулганы 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-ынхэрэгжилтийн хүрээнд дэлхий дахинд үүсээд байгаа цар тахал буюу корона вируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын улмаас улс орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл

байдал хүндэрч, аж ахуйн нэгж, байгууллагын орлого буурч, үйл ажиллагаа нь доголдож байгаатай холбогдуулан нийт аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран зохион байгуулж ажиллаж байна.Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллага болон түүнд ажиллаж байгаа Монгол Улсын иргэн даатгуулагч нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс бүрэн, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх 1.0 хувь, ажил олгогч 3.0-3.5 хувь, даатгуулагч 4.5 хувь, сайн дурын даатгуулагч 25 200 төгрөгөөр тус тус чөлөөлөгдөж байна.Нийслэлийн хэмжээнд **26548** аж ахуй нэгж, **429990** албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагч **56171**, 0-3 насны хүүхэдтэй эх **4157** хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдсан байна.







САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧ ТА НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ ДАРААХ БАЙДЛААР ТООЦООЛООРОЙ

/төгрөгөөр/

| Сайн дурын даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн сарын орлого | Шимтгэл тооцох хувь хэмжээ | Төлвөл зохих НДШ | 2021.07.01 хүртэл | |
|---|---|---|---|---|
| | | | Өөрөө хариуцан төлөх | Чөлөөлөгдөх |
| 420 000 | 14.5% | 60 900 | 35 700 | 25 200 |
| 600 000 | | 87 000 | 61 800 | |
| 1 000 000 | | 145 000 | 119 800 | |
| 4 200 000 | | 609 000 | 583 800 | |

| 0-3 насны хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эхийн өөрөө мэдүүлсэн сарын орлого | Шимтгэл тооцох хувь хэмжээ | Төлвөл зохих НДШ | 2021.07.01 хүртэл | |
|---|---|---|---|---|
| | | | Өөрөө хариуцан төлөх | Чөлөөлөгдөх |
| 420 000 | 13.5% | 56 700 | 26 250 | 30450 |
| 6 00 000 | 14.5% | 87 000 | 52 350 | 34650 |
| 1 000 000 | | 145 000 | 110 350 | |
| 4 200 000 | | 609 000 | 574 350 | |

- Сарын шимтгэлээ төлснөөр таны гэрээ өмнөх гэрээний хугацаагаар сунгагдана.
- Банкны цахим үйлчилгээ /интернэт банк, мобайл банк, Qpay/-г ашиглан шимтгэлээ төлөөрэй.
- "Нийгмийн даатгал" гар утасны аппликэйшнээр шимтгэлийн тооцооллоо хялбар хийж, гэрээгээ сунган, төлбөр төлөх банкны системд шууд холбогдох боломжтой.

7777 1289 sigomongolia www.ndaatgal.mn

❖ Даатгуулагч, иргэн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, төлбөр зардал авахад шаардагддаг архивын лавлагааг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс хооронд явж баримтын бүрдүүлэлтээ хийж, цаасан лавлагаа авдаг байсан бол одоо иргэний өмнөөс аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд хоорондоолавлагааг цахимаарсолилцож, даатгуулагчийн цаг хугацаа, зардлыгхэмнэжбайна. 2021 оны 11дугаар сарын 30 байдлаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд ***8765*** **/**давхардсан тоогоор**/** лавлагааг солилцож шийдвэрлэсэн байна.Мөн иргэд даатгуулагч НДХэлтэст очилгүйгээр e-mongolia.mn сайт болон emongoliaгар утасны аппликэйшнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо үнэ төлбөргүй татаж авах, хэвлэн ашиглах боломжтой болсон.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн орон тоог 433 орон тоотойгоор баталсан бөгөөд 2021 оны 12 сарын 14-ны өдрийн байдлаар 432 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

| № | Үзүүлэлт | Нийт тоо | Багануур | Багахангай | Баянгол | Баянзүрх | Налайх | Сонгинохайрхан | Сүхбаатар | Хан-Уул | Чингэлтэй | Нийслэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Батлагдсан орон тоогоор ажиллавал зохих нийт ажилтнууд | 433 | 20 | 6 | 63 | 65 | 23 | 62 | 58 | 50 | 61 | 25 |
| | Үүнээс: Удирдлага | 10 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | Гүйцэтгэх ТЗ-ТҮ | 374 | 16 | 5 | 54 | 60 | 17 | 52 | 52 | 43 | 52 | 23 |
| | үйлчлэх /жолоочүйлчлэгч/ | 21 | 2 | 0 | 3 | 3 | 2 | 4 | 2 | 2 | 2 | 1 |
| | Гэрээт | 28 | 1 | 0 | 5 | 1 | 3 | 5 | 3 | 4 | 6 | 0 |
| 2 | Одоо ажиллаж байгаа нийт ажилтнууд | 432 | 20 | 6 | 63 | 67 | 22 | 62 | 58 | 55 | 54 | 25 |
| | Үүнээс: Удирдах | 10 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | Гүйцэтгэх | 383 | 16 | 5 | 58 | 63 | 16 | 54 | 52 | 51 | 45 | 23 |
| | Үйлчлэх /Жолоочүйлчлэгч/ | 39 | 3 | - | 4 | 3 | 5 | 7 | 5 | 3 | 8 | 1 |



**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тус газар нь 8 зорилтын хүрээнд ажил төлөвлөж газрын даргаар батлуулаа. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд:

1. Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулав.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23,5 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилж байна. Тус газар 12 сарын байдлаар 4 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулсан.

3. Албан тушаалтанд холбогдох авлига ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээс авах зорилгоор албаны утас болон цахим хуудсыг ажиллуулж байна.

4. Нийгмийн даатгалын хууль тогтоомж хэрэгжүүлэхэд иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх зорилгоор ямар үйлчилгээ авахад ямар материал бүрдүүлэх, хаана хандах зэрэг асуудлын талаар цахим хуудсаар мэдээлэх, нийтэд хамааралтай журмыг цахим хуудсанд байрлуулах, сурталчлах, таниулах арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

5. Авлигын эсрэг хуулийн дагуу жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тус газрын 19 мэдүүлэг гаргагчийн 2020 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган, ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангаар гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.

***Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:***

Тус газар нь “ Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаатай батлуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2 дэд хэсэгтэй нийт 15 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллалаа. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, 2016-2019 оны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог сайжруулах асуудлын хүрээнд ажиллах таатай орчныг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор

хангах, албан хаагчдын эрүүл мэнд ажил, амралтын зохистой харьцааг тогтоох, чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх, ажлын байранд мэргэшүүлэх ур чадварыг дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.Хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1.2021 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 26 албан хаагчдад нийт 314,940,300 төгрөгийн цалин, хоол унааны нэмэгдэлд 29,150,000 төгрөг, зэрэг дэв, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 23 албан хаагчдад 113,549,700 төгрөгийг тус тус олгосон.

2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан тус газрын 51 хүүхдэд 1 550 000 төгрөгийн гарын бэлэг гардуулсан.

3.Ажиллагсдад тохиолдсон өвчин зовлон, гачигдлыг хамт олноороо хуваалцдаг, сэтгэлийн болон эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлж, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу буцалтгүй тусламж олгож байна. Баяр ёслол, тэмдэглэлт ой, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлдэг, явган аялал, зугаалга зохион байгуулах зэргээр ажиллагсдыг ая тухтай, зөв зохистой амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахаас гадна спортын арга хэмжээнд жил бүр идэвх санаачилгатай оролцож байна.

4.Тус газрын бичиг хэрэг архив хариуцсан ажилтанд сар бүр 15-ны өдрийн дотор хамтын хуримтлалын фондоос 20 000 төгрөгийг үнэ бүхий сүү тараг өгөх зохион байгуулж ажиллаа.

GREEN ERP программын хөгжүүлэлтийн сургалтыг НДЕГ ITZONE хамтран хэрэгжүүлсэн ба тус сургалтад нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүд хамрагдсан. Уг программыг нэвтрүүлснээр

- Нийт албан хаагчдын мэдээлэл нэг дор төвлөрсөн
- Орон тооны төлөвлөгөөгөө хянах боломжтой болсон
- Хөдөлмөрийн харилцааны гол хэсэг болох гэрээ тушаал шийдвэрүүд нэгдсэн загвартай болно
- Албан хаагчдын ажилласан цагийн тайлан гаргахад хялбар болсон. Программ нэвтэрч байгаатай холбоотой зарим цагийн машингүй хэлтэс цагийн машин суулгасан.

Энэхүү программ нь Төрийн албан хаагчийн анкетыг цахим байдлаар системийн хэмжээнд бүрэн оруулах боломжийг бүрдүүлсэн. Программаас бүх төрлийн судалгааг гаргах боломжтойгоор шийдлийг хийж програмчлалын боловсруулалт хийгдсэн бөгөөд хүний нөөцийн талаар цаг тухай бүр шийдвэр гаргахад Хүний нөөцийн программаас шаардлагатай мэдээллийг гарган удирдлагыг шуурхай, үнэн бодит мэдээллээр хангаан ажиллах боломж бүрдсэн юм.

5. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн систем, Able программын хүний нөөцийн систем, GREEN ERP хүний нөөцийн программыг нэвтрүүлж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд хүний нөөцийн удирдлагын талбарт албан хаагчдын мэдээлэл, тухайн жилд томилогдсон, чөлөөлөгдсөн, халагдсан албан хаагчдын мэдээллийн талаарх өөрчлөлтийг программд бүрэн тусгаж, мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэд оруулан ажиллаж байна.

6.Нийгмийн даатгалын салбарыг хөгжүүлэх үйлсэд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын 19 албан хаагчдыг Нийслэлийн нийгмийн даатгалын газрын “Жуух бичиг”-ээр шагнав.

7. Тус газрын Ёс зүйн зөвлөл нь газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Ёс зүйн зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, тэдгээртэй холбоотой ёс зүйн зөрчлийг шалган тогтоох чиг үүрэгтэйгээр ажилладаг. Зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 273 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм-ийг тус тус мөрдөж ажиллаж байна. . Ёс зүйн зөвлөл нь 2021оны 12 дугаар сарын байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлээгүй болно.

***Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:***

1. Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан байгууллагын системийн хэмжээнд нийт ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн авч хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, баяжилтыг хийх зорилгоор хуучин хувийн хэргийг нь шинээр бүрдүүлж өгсөн хувийн хэрэгтэй нь нэгтгэж бүх мэдээллийг тулган шалгаж, шинээр хавтаслан албан хаагчдын хувийн хэргийн мэдээллийг баяжуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулан Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажилласан.

2.Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2019 20 дугаар тогтоолын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай, А/452 тоот захирамжаар 120 албан хаагчдад зэрэг дэвийн шатлал ахиулсан.

3. Мөн тус газар 2021 оны  хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой 23  хүний нөөцтэй холбоотой  7 тушаал батлагдсан гарсан бөгөөд тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

***СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН***

### *Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын чиглэлээр*

“Менежмент ба ур чадварын хүрээлэн”-тэй хамтран Нийслэлийн засаг даргын тамгын газраас санаачлан зохион байгуулсан **“ЗӨВ МЕНЕЖМЕНТ- ЗӨВ ТОГТОЛЦОО”** стандарт танилцуулах сургалтад тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, Архив, бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл нар хамрагдсан.







2021 оны 02 дугаар сарын 02-нд Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, өргөдөл гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоох, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулж, хугацаа зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулагдсан цахим сургалтад Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл оролцсон.

Нийслэлийн архивын газраас “Албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй” “Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн хэрэглээ” “Хяналтын үйл ажиллагаанд анхаарах зүйлс” Сэдвээр 2021 оны 03 дугаар сарын 23-нд сургалт авч 23 албан хаагч хамрагдав.

Мөн Нийслэлийн архивын газраас 2021 оны 05 сарын 21-нд “erp. ulaanbaatar.mn”Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд “Баримт бичиг боловсруулах, тоон гарын үсгийн ашиглалт” сэдвээр

цахим сургалтыг googlemeet  программаар онлайнаар зохион байгуулсан бөгөөд сургагч багшаар  Нийслэлийн архивын газрын сургалт хариуцсан мэргэжилтэн Д.Бумдарь,  Систем хариуцсан мэргэжилтэн  Р.Саранцэцэг нар ажилласан.















НДЕГ, ITZONE компани хамтран хэрэгжүүлж байгаа GREEN ERP программын хөгжүүлэлтийн сургалтад уулзалт хэлэлцүүлэгт нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 8 удаа хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын мэдээллийн системийн танилцуулах сургалтадГазар хэлтсийн дарга нар, газар хэлтсүүдийн хүний нөөцийн ажилтан, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн, архив бичиг хэргийн ажилтан, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадваржуулах, MS, EXCEL программын сургалтад тус газрын хүний нөөц, хууль эрхзүй хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа 2021.04.15-ний өдөр хамрагдсан.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас /JICA/ “Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн дүн шинжилгээний практик ур чадварыг бэхжүүлэх” онлайн сургалтыг зохион байгуулж тус газрын Санхүү бүртгэлийнхэлтсийн **6** албан хаагч 2021 оны 03 дугаар сарын 04-өөс 03 дугаар сарын 19-ний хооронд онлайн хэлбэрээр хамрагдсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас Авлигатай тэмцэх газартай хамтран 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт цахим сургалтад Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа хамрагдлаа. Сургалтад авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Б.Тэрбиш “Төрийн албан хаагчийн ёс зүй” тус хэлтсийн ажилтан М.Жамъянчойжил “Харилцаа ба хандлага” сэдвээр хичээлийг зааж явуулсан.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91-р тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас http://surgalt.unelgee.gov.mn вэб хаягт байршуулсан "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ" сэдэвт 4 модуль цахим хичээлийг 4 дүгээр сарын 23-30 хооронд бүх албан хаагчдад танилцуулж, судлуулах ажлыг зохион байгуулж үр дүнг тооцож ажиллаа.







Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн системийн шинэ хувилбарт шилжиж буйтай холбогдуулан системтэй хэрхэн ажиллах вэ? Шинэ хувилбарын хэрэглэгчийн гарын авлага танилцуулах сургалтад 2021 оны 01 сарын 27-ний өдөр Хууль эрх зүй хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамрагдсан.








“ТАЦНС-ЭЭР ЦАЛИН ХӨЛСИЙГ ТООЦООЛОХТОЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АСУУДЛУУД” сэдэвт цахим хэлэлцүүлгийн хөтөлбөр

05/20/2021

11:10-11:15 Цалин хөлсний тооцоололтой холбоотой аудитаар илэрдэг түгээмэл алдаа, арилгах арга зам
Ц.Наранчимэг
ҮАГ-ын Монгол улсын Ерөнхий Аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

11:15-11:20 Ээлжийн амралтын нөхөх олговор тооцоолох, сахилгын шийтгэл ногдуулах аргачлал
Б.Алимаа
ХНХЯ-ны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

11:20-11:25 Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтны цалин хөлс тооцоолоход анхаарах зүйлс, цалингийн шатлалыг хэрхэн тогтоох вэ?
Я.Хишигт
Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөц, аудитын газрын дарга

11:25-11:30 Шимтгэл төлөлтийн тайлан гаргахад анхаарвал зохих зүйлс, хууль эрх зүйн шинэчлэлт
С.Лхагвадорж
НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт судалгааны газрын ахлах мэргэжилтэн

11:30-11:35 Татвар ногдуулах орлого, ТТ-11 тайлан гаргахад анхаарвал зохих зүйлс, хууль эрхзүйн шинэчлэлт
Б.Энхтөр
ТЕГ-ын Татвар төлөгчдөдүйлчлэх газрын татварын улсын ахлах байцаагч

11:35-11:40 “Төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын төслийн танилцуулга
Б.Болормаа
Сангийн яамны НБББГазрын ахлах мэргэжилтэн

11:40-12:30 АСУУЛТ, ХАРИУЛТ нягтлан бодогчдоос ТАЦНС-ийн пейж хуудсаар урьдчилан ирүүлсэн асуултад оролцогчид хариулна

2021 оны 05 сарын 20-ны өдөр Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн “Цалин хөлсийг тооцоолохтой холбоотой зарим асуудлууд” сэдэвт сургалтад Санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Сумьяасүрэн хамрагдлаа.

### *Төрийн байгууллагын мэдээллийн урсгалыг сайжруулах цахим сургалт*

Нийгмийн даатгалын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдийн сошиал маркетингийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийттэй харилцах ур чадварыг сайжруулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2021 оны 05 сарын 21-нд зохион байгуулсан цахим сургалтанд Сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав оролцов.





### *Ёс зүйн сургалт:*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын ёс зүйн зөвлөлөөс аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүдийг хамруулсан цахим сургалтанд 2021 оны 06 сарын 14-нд тус газрын тамгын хэлтсийн дарга, Ёс зүйн зөвлөлийн дарга О.Байгалмаа, нарийн бичигийн дарга хяналт шалгалтын байцаагч Э.Болормаа, ёс зүйн зөвлөлийн гишүүн хүний нөөц хууль эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Ахлах нягтлан бодогч Ахлах мэргэжилтэн М.Цандмаа, Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн дарга Л. Очирбал нар хамрагдав.




***Төрийн албаны тухай хууль, Архив бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт***

Төрийн албаны зөвлөлөөс Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Архивын ерөнхий газартай хамтран Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “ Төрийн албаны тухай хууль Архив бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт” сэдэвт сургалтад 2021 оны 06 сарын 18-ний өдөр Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, Хүний нөөц, хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Гэрэлмаа, Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл нар хамрагдав.





***Нийслэлийн сургалт судалгааны төвийн сэдэвчилсэн сургалтууд 6 сар***

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан “Албан бичгийн найруулга зүй, албан хэрэгт цахим хэрэглүүр ашиглах нь, Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг” сэдэвт сургалтад 2021 оны 06 сарын 21-нд Тамгын хэлтсийн Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, Хууль эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Санхүүгийн хэлтсийн Үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Сумьяасүрэн, Хөрөнгө хариуцсан мэргэжилтэн Б.Солонго, Б.Санжаасүрэн, Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга Л.Очирбал, Б.Цэрэнчимэд, Б.Батцэрэн нар хамрагдлаа.





### *Нийслэлийн сургалт судалгааны төвийн сэдэвчилсэн сургалтууд 8 сар*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн 8 дугаар сарын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ дээшлүүлэх” нь сэдэвт сургалтад Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, хяналт шалгалтын байцаагч Э.Өрнөл, Хөрөнгө хариуцсан мэргэжилтэн Б.Солонго нар, “Баг хамт олны үр дүнтэй харилцаа” ахлах мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад Хяналт шалгалтын ахлах байцаагч О.Ууганбаатар, Ахлах мэргэжилтэн ахлах нягтлан бодогч М.Цандмаа нар хамрагдав.

Энэхүү сургалт нь: Цахим орчинд хэрхэн хялбараар бэлэн загвар, вэб - д суурилсан программ хангамжуудыг хэрхэн ашиглах, цахим орчинд хурдан хялбар аргаар ажиллаж ажлын бүтээмжээ дээшлүүлэх талаар маш сонирхолтой үр өгөөжтэй сургалт тул нийт албан хаагчдыг 2022 онд хамруулахаар төлөвлөж байна.

### *Залуучуудын хөгжлийн зөвлөлийн сургалт хэлэлцүүлэг*

Монгол Улсад залуучуудын байгууллага үүсч хөгжсөний түүхэн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх байгууллага бүр “Залуучуудын зөвлөл” байгуулж ажиллах тухай сургалт хэлэлцүүлэгт Тамгын хэлтэс сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав оролцож, 8-р сарын 25-нд ХНХЯ, Монголын залуучуудын холбоо, Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Залуучуудын байгууллага 100 жил” үндэсний цахим чуулганд оролцлоо.







### *Нийслэлийн сургалт судалгааны төвийн сэдэвчилсэн сургалтууд 9 сар*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн 9 дүгээр сарын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “poiwerpoint программ дээр танилцуулга бэлтгэх арга аргачлал” “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт сургалтуудад Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, бодлогын хэрэгжилт тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Х.Заяа, хяналт шалгалтын байцаагч Э.Болормаа нар хамрагдав.






***“Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх” нь төслийн сургалт***

Төрийн албаны зөвлөлөөс Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх” нь төслийн сургалт хэлэлцүүлэгт Хүний нөөц, хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа хамрагдав.

***Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн прокурорын газрын хамтарсан сургалт***

2021 оны 10 сарын 06 өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн Прокурорын газартай хамтран “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах” нь сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж энэхүү сургалтад Хүний нөөц, Хууль эрзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Хяналт шалгалтын байцаагч Э.Болормаа нар хамрагдав.





***Тагнуулын ерөнхий газар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн сургалт:***

Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулж байгаа “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгох цахим сургалтад  Байгууллагын нууц хамгаалах ажилтан Тамгын хэлтсийн дарга  О.Байгалмаа  цахимаар оролцлоо.







***Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын алба хаагчдад зориулсан “Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт” сэдэвт сургалт***

2021 оны 10 сарын 21-нд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын  алба хаагчдад  зориулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэсээс  зохион байгуулсан  “Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт” “Гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа”  сэдэвт  цахим сургалтад  Тус газрын 18 албан хаагч хамрагдав.







### *Баасан гаригийн сургалт мэдээллийн цаг:*

НДЕГ-аас Баасан гаригийн өглөө бүр нийт албан хаагчидад зориулж “Мэдээллийн цаг”арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд мэдээллийн цагаар нийгмийн даатгалын салбарын цаг үеийн мэдээлэл болон ажилтан албан хаагчдад чиглэсэн мэдээ, мэдээлэл богино хугацааны сургалт хийгддэг.

2021 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн Баасан гаригийн мэдээллийн цагийг Нийслэлийн нийгмийн даатгалын газраас зохион байгуулж оньсон тоглоомын төрөл зүйлээс заалгаж, хамтдаа тоглож, хүүхдийн танин мэдэхүй, сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэхэд оньсон тоглоом, шагайн наадмын ач холбогдлын талаар танин мэдэхүйн мэдлэг мэдээлэл бүхий “Монголчуудын уламжлалт тоглоом наадгайн соёл”-ын талаар Олон Улсын оюун ухааны музейн дэргэдэх “Оюуны оньс” дунд сургуулын багш Э.Энхтөрийг урьж сонирхолтой илтгэл хэлэлцүүллээ.





### *Жендерийн үндэсний хорооны сургалт*

Нийслэлийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан жендэрийн асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах цахим сургалтыг Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Жендэрийн үндэсний хороотой хамтран зохион байгуулсан бөгөөд тус сургалтад Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа,

тамгын хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар оролцлоо.







### *Нийгмийн даатгалын мэдээллийн системийн сургалт /ITZone/*

Азийн хөгжлийн банкны “Хүнс тэжээл, нийгмийн хамгаалал –Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Ай ти зон ХХК-ний хооронд байгуулсан гэрээний дагуу “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” ажлын хүрээнд явагдаж байгаа сургалтуудад Санхүүгийн болон Тамгын хэлтсийн мэргэжилтнүүд 2021 оны 11 дүгээр сарын 13-аас эхлэн цахимаар оролцож байна.

### *Улсын байцаагчийн эрх олгох шалгалтын тухай*

Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/252 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”-д нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад нийгмийн даатгалын ажилтнууд 3 жил тутамд хамрагдахаар заасны дагуу

**2021** оны **11** дүгээр сарын **16-23** ний хооронд Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэгчдэд зориулсан 5 удаагийн сургалтыг https://ndaatgal.gosmart.mn цахим сургалтын динамик платформыг ашиглан явуулсан бөгөөд тус газраас давхардсан тоогоор 45 албан хаагч хамрагдав.

### *Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалт*

Нийслэлийн засаг даргын тамгын газраас Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран Засаг даргын тамгын газар харьяа агентлагуудын хүний нөөц, Захиргаа удирдлагын газрын дарга нарыг хамруулсан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг танилцуулах танхимын сургалт хэлэлцүүлгийг 2021 оны

11 дүгээр сарын 16-ний өдөр танхимаар зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа хамрагдав.





### *Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ийн сургалт*

НДЕГ-аас Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ 2021-2024 онд хамтран ажиллах хөтөлбөрийн хүрээнд 2021.11.22-2021.12.13 “Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн дүн шинжилгээний практик ур чадварыг бэхжүүлэх” нь онлайн сургалтад Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга С.Ундармаа, Ахлах нягтлан бодогч, Ахлах мэргэжилтэн М.Цандмаа нар хуваарийн дагуу оролцож байна.





### *Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлийн Пүрэв гаригийн цуврал сургалтууд*

2021 оны 10 сарын 14-ний өдөр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас: Худалдан авах ажиллагааны шинэчилсэн бодлогын баримт бичгийг танилцуулга, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга

хэлэлцүүлэгт Санхүү бүртгэлийн хэлтсийн Үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Сумьяасүрэн хамрагдлаа.

2021 оны 11 сарын 04-ний Пүрэв гаригийн сургалтаар “Төрийн албаны сонгон шалгаруулалтын өнөөгийн байдал” сэдэвт сургалтад Хүний нөөц, хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа хамрагдав.

2021 оны 11 сарын 11-ний Пүрэв гаригийн сургалтаар Нийслэлийн засаг даргын тамгын газар төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гариг болгон зохион байгуулдаг цуврал сургалтын хүрээнд “Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах” нь сэдэвт сургалтад Хүний нөөц, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжитэн Л.Гэрэлмаа, Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамрагдав.

2021 оны 11 сарын 25-ний Пүрэв гаригийн сургалтаар Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, анхаарах асуудал” сэдэвт сургалтад мөн хүний нөөц хууль эрхзүйн асуудал хариуцсан Л.Гэрэлмаа цахимаар хамрагдлаа.















Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 78-р тогтоолоор Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд 2 удаагийн дотоод цахим сургалтаар 47 /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулсан.

2021 оны 04 сарын 15-нд газрын Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар “Нийгмийн даатгалын тухай хуульд 2020-2021 онд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” “Нийгмийндаатгалын цахим үйлчилгээ”-ний талаар сургалт хийж 24 албан хаагч, 2021 оны 04 сарын 21-нд хяналт шалгалтын байцаагч Б.Батцэрэн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай ерөнхий ойлголт, тэтгэвэр тогтоолт, олголтын талаарх анхаарах асуудал” сэдвээр сургалт хийж 23 албан хаагчид хамрагдав.













Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацын газрын дэргэдэх "Улаанбаатар инновацын төв", "Баянхошуу бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төв"-ийн Бизнес инкубатор хөтөлбөрт шалгарсан гарааны компаниудад зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд Хяналт, шалгалт дотоод аудитын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, Сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар "Нийгмийн даатгалын тогтолцоо, нийгмийн даатгалд даатгуулах ач холбогдол" "Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ" сэдвээр 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 16:00 цагт сургалт зохион байгуулж илтгэл танилцууллаа. Сургалтад 15 инкубатор компанийн 29 хүн хамрагдсан. Google meet платформоор, OBS программ ашиглан ФЕЙСБҮҮК хуудсаар шууд дамжуулсан.







Албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг албан салбарт шилжүүлэх сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн ач холбогдлыг таниулах зорилгоор Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Сургалт судалгааны төв, Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран 2021 оны 11 дүгээр сарын 02-ний өдрөөс 11 сарыг дуустал Нийслэлийн төвийн 6 дүүргийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан нийт 3000 иргэнийг хамруулах зорилготой багц сургалтыг Хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар нийт 5 удаа зохион байгуулж 1000 гаруй иргэн хамрагдсан бол Дүүргийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүд тус бүр нэг, нэг удаазохион байгуулж нийт **2704** иргэнд мэдээ




мэдээлэл хүргэж ажиллаа










Олон нийт мэдээллийн хэрэгсэл, сайт, page хуудсаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг сурталчлах ажлын хүрээнд 2021 оны байдлаар Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь https://daatgal.ub.gov.mn/ албан ёсны вэб сайт болон “Нийслэлийн нийгмийн даатгалын газар” фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчлан таниулах, мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэж ажиллалаа. Нийслэлийн нийгмийн даатгалын газар пэйж хуудас**24665** дагагчтай байсан бол **26,249** болж өнгөрсөн оны мөн үеэс **1584** өссөн дүнтэй байна.

2021 оны байдлаар ХНХЯ, НДЕГ-аас бэлтгэсэн болон тус газраас бэлтгэн гаргасан **262 удаагийн** пост мэдээ шинээр оруулж чат, болон комментоор иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл тогтмол өгч ажиллаа. https://daatgal.ub.gov.mn/сайтаар дамжуулан 33 удаагийн мэдээ мэдээлэл пост оруулж Хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдал зэрэг мэдээллийг түргэн шуурхай цаг тухай бүр шинэчлэн ажиллаа.

Нийслэлийн засаг даргын 2021 оны А/746 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа газар, инженер хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, таниулах “Нээлттэй хаалганы нэг сар” өдөрлөгт Тус газрын **13** албан хаагч төв талбайд халдвар хамгааллын дэглэмээ баримтлан оролцож нийт **89** иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч **1** өргөдөл хүлээн авч, **6** даатгуулагчийн гар утасны аппликэйшн баталгаажуулж ажиллаа.

Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл иновацийн газраас санаачлан Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч 34 агентлагуудын дунд албан ёсны олон франчайз “Ignite talk”эрхийн дагуу байгууллага бүр өөрсдийнүндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг олон нийтэд сурталчлан таниулах

зорилгоор “City Agencies Ignite talk” арга хэмжээнд оролцож нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл өгч ажиллаа.

“Ignite talk” арга хэмжээ анх 2006 онд Вашингтоны Сиэтл хотод зохион байгуулагдсан бөгөөд илтгэлийн өвөрмөц форматаар нэгтгэн хүргэдэг илтгэгч бүр 20 слайдыг ашиглах бөгөөд 15 секунд тутамд автоматаар зураг солигдон. Үр дүн нь хурдан бөгөөд өвөрмөц сонирхолтой илтгэлүүд ердөө 5 минут үргэлжилнэ.

Тус арга хэмжээг Нийслэлийн мэдээ, hub innovation center фэйсбүүк хуудсаар лайваар шууд дамжуулсан.

Хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд нь тус телелвизд цар тахалтай холбоотойгоор Коронавирусээр өвчилж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авагчдын тоо ихээр нэмэгдсэнтэй холбогдуулан нийслэлийн нийгмийн даатгалын харьяа есөн дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн эрүүл мэндийн хуудасны нөөц хүртээмжийн талаар ерөнхий мэдээлэл хүргэсэн ярилцлага өгөв






***Төрийн албаны зөвлөл, НҮБХХ хамтран хамтран зохион байгуулсан сургалт***

2021 оны 10 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд Канад Улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөл, НҮБХХ хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл Үр дүнд суурилсан нэгдсэн тогтолцоо буюуIntegrated Results Based Management арга зүйн болон цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлагын уялдааг хангахад чиглэсэн шийдэл, арга зам гаргах зорилго бүхий сургалтад хууль эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа хамрагдав. Сургалтаар багаар ажиллаж ёс зүйн зөрчлийг үүсгэх хүчин зүйлсийг тодорхойлох, мэдлэг, ур чадвартай болж, төрийн албан хаагчийн цогц чадамжийн ойлголт, цогц чадамжийг нэвтрүүлснээр бий болох үр нөлөө, ач холбогдлыг таниулах, чадахуйн зарчмыг хамгаалах ёс зүйтэй төрийн бодлогыг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс сэргийлэхэд ашиглах шинэ мэдлэг, инновац зэрэг ур чадварыг эзэмшиж үүнийгээ албан тушаалын тодорхойлолтод болон гүйцэтгэлийн удирдлагад хэрхэн тусгах вэ? зэрэг асуудлаар олон улсын зөвлөх, үндэсний шинжээч болон мэргэжилтнүүд сургалт явууллаа.

## АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Газрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Баримт бичгийн стандарт / MNS5140:2011-1,2,3/, Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, заавар” “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, зэрэг бусад эрх зүйн актад нийцүүлэн хөтлөн явууллаа.

Тайлант хугацаанд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ болох www.edoc.ulaanbaatar.mn программ болон www.intranet.gov.mn дээр нийт **599** албан бичиг нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс ирсэн байна. Үүний **128** албан бичиг нь хариутай **471** хариугүй албан бичгийг хүлээн авсан байна. Хэлтэс тус бүрээр нь авч үзвэл Тамгын хэлтсийн албан хаагчдад нийт **397** албан бичиг ирсэн бөгөөд үүнээс **104** албан бичиг хариутай,**293**хариугүйалбан бичгийг хүлээн шийдвэрлэсэн ажилласан байна. Санхүү бүртгэлийн хэлтэст нийт **90** албан бичиг ирсний **10** хариутай **80** хариугүй албан бичгийг шийдвэрлэсэн байна. Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэст **112** албан бичиг ирсэн бөгөөд үүний **14** хариутай,**98** хариугүй албан бичгийг шийдвэрлэсэн байна.

Мөн тайлант хугацаанд нийт **256** албан бичгийг төлөвлөн боловсруулан явуулсан бөгөөд Тамгын хэлтэс **143**Санхүү бүртгэлийн хэлтэс **42**

-Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэс **71** албан бичгийг НДЕГ болон НЗДТГ хүргүүлэн ажилласан байна.

E-DOC системийг ашиглан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай албан бичиг солилцох, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж, 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс бүрэн ашиглаж эхэлсэн.

Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамжийн дагуу албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалд, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системhttps://edoc.ulaanbaatar.mn/ системээрхөтлөн явуулж байна.

Байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох www.intranet.gov.mn ирсэн явсан албан бичгийг хариуцсан ажилтан хаагч нарт удирдлагын цохолтын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллав.

Захирамжлалын албан бичгийг үг үсгийн болон утга найруулгын хувьд алдаатай эсэхийг шалган албан бичгийн боловсруулалтын стандартыг мөрдөж ажиллаа.

Явсан албан бичигт нэгжийн индексийн дугаар өгөн огноог тэмдэглэн төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан тоон гарын үсгээр баталгаажуулан e-doc программ ашигладаг байгууллагуудад илгээж харин тоон гарын үсэг ашигладаггүй байгууллагуудад даргын гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэн ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /https://edoc.ulaanbaatar.mn/-ээр болон байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох able-р албан бичгийг цахимаар илгээж цаасан суурьтайгаар илгээх албан бичгийг шуудангаар хүргүүлэн ажиллажээ.

## ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Өргөдөл гомдол хүлээн авах онлайн программ болох smartcity.mn программ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод систем болох https://erp.ulaanbaatar.mn/ байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох able-д өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авч, холбогдох албан хаагчдад удирдлагын заалтын дагуу шилжүүлэн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж, шийдвэрлэсэн хариуг албан бичгээр болон бусад байдлаар хүргүүлэн ажиллалаа.

Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд Call-Pro үйлчилгээг байгууллага дээрээ нэвтрүүлсэнээр иргэдээс ирэх өргөдөл, гомдол багасаж байгаа нь ажиглагдаж байна. Дүүргүүд дуудлага алдахгүй иргэдэд түргэн шуурхай мэдээлэл өгч байгаа нь манай

Жилийн эцсийн байдлаар **218** өргөдөл гомдлыг хүлээн аван удирдлагад танилцуулан ажилласан байна. Тамгын хэлтэс **76,** Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс **140,** Санхүү бүртгэлийн хэлтэс **2** өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажилласан байна. **13** өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэх шатандаа явж байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94,4% тай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа **9** хоног **19** цаг **5** минут байна.

**2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ННДГ-Т ХАНДАН ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

| № | Байгууллагын нэр | Шийдвэрлэлт | | | | | Шийдвэр-лэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт өргөдөл гомдлын тоо | Шийдвэр-лэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүл-сэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Шийдвэрлэх шатандаа байгаа | |
| **1** | ННДГ | 218 | 206 | 87 | 11 | 13 | 94,4% |
| | ДҮН | **218** | **206** | **87** | **11** | **13** | **94,4%** |

### 2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ННДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл,гомдол, санал, талархал, хүсэлт /хэлбэрээр/

| № | Байгууллагын нэр | Шийдвэрлэлт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт өргөдөл гомдлын тоо | 1800-1200 тусгай дугаар-ын утас | Гар утасны аппликейшнээр ирсэн | Засгийн газрын 11-11 төв | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | Нутгийн захиргааны байгууллагууд | Check my service аппликейшн |
| 1 | ННДГ | 218 | 58 | 3 | 72 | 3 | 66 | 16 |
| | ДҮН | **218** | **58** | **3** | **72** | **3** | **66** | **16** |

### 2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ННДГ-т иргэдээс 11-11 төвд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, талархал, санал, хүсэлт

| № | Байгууллагын нэр | 11-11 төвөөр | Тусгай дугаарын утсанд хандсан |
|---|---|---|---|
| 1 | ННДГ | 72 | 58 |
| | ДҮН | **72** | **58** |

### 2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ННДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл /агуулгаар/

| № | Өргөдлийн хэлбэр | Өргөдлийн тоо |
|---|---|---|
| **1** | Талархал | 1 |
| **2** | Гомдол | 139 |
| **3** | Санал | 4 |
| **4** | Хүсэлт | 73 |
| **5** | Мэдээлэл | 1 |
| | **Нийт** | **218** |

### 2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ННДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл /хандалтаар/

| Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдлын эзлэх хувь/ |
|---|

1. Санал - 4 /1,83%/
2. Гомдол - 139 /63,7%/
3. Хүсэлт - 73 /33,4%/
4. Талархал -1 /0,4%/
5. Мэдэгдэл -1 /0,4%/




*Агуулгаар нь авч үзвэл:*

- ✓ Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай **57 буюу 10,92%**
- ✓ Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын тухай **64 буюу 30,33%**
- ✓ Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны үйл ажиллагааны тухай **23 буюу 10,9%**
- ✓ Ажилгүйдлийн даатгалын тухай **15 буюу 7,11%**
- ✓ Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай **16 буюу 7,58%**
- ✓ Үйлчилгээний болон бусад салбарын албан хаагчийн ёс зүйн тухай **4 буюу 1,9%**
- ✓ Тэтгэврээ шинэчлэн тогтоохыг хүссэн тухай **7 буюу3,32%**
- ✓ Бусад салбарын үйл ажиллагааны тухай **12 буюу 5,5%**
- ✓ Ажилд шилжих тухай **2 буюу 0,95%**
- ✓ Ээлжийн амралтын тухай **1 буюу 0,47%**
- ✓ Бусад **17 буюу 7,79**

Өргөдлийн гомдлын зөрчлийг үе шаттайгаар бууруулах шаардлагатай байна.

1. Өргөдөл гомдлыг шилжүүлсний дараа ажлын 8 цагт багтаан хүлээн авч танилцах, шилжүүлэх шийдвэрлэх,
2. Удирдлагаас заалтын дагуу шилжүүлсэн өргөдөл, гомдлыг ажилтан, албан хаагч нар түргэн шуурхай нээж танилцах,
3. Тухайн өргөдөл гомдлыг хариуцсан албан хаагч нараар 10 хоног тутамд явцын тэмдэглэл хөтлүүлж байх,
4. Шийдвэрлэхэд дөхөм өргөдөл гомдлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлүүлэх ингэснээр зөрчлийн тоо буурч, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацааг буурна.

## 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАНДАН ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хүснэгт 1

| № | Байгууллагын нэр | Шийдвэрлэлт | | | | | Шийдвэрлэлт /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт ирсэн өргөдөл гомдлын | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа Хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |

| | | *тоо* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | ННДГ | 218 | 206 | 87 | 11 | 12 | 94,4% |
| **2** | БГД НДХ | 1436 | 1391 | 0 | 1 | 45 | 96,8% |
| **3** | ЧД НДХ | 576 | 533 | 0 | 0 | 43 | 92,4% |
| **4** | БЗД НДХ | 1741 | 1730 | 0 | 0 | 11 | 99,3% |
| **5** | СХД НДХ | 2425 | 2421 | 0 | 0 | 4 | 99,8% |
| **6** | СБД НДХ | 623 | 576 | 0 | 25 | 47 | 92,4% |
| **7** | ХУД НДХ | 1214 | 1151 | 0 | 0 | 63 | 94,8% |
| **8** | БХД НДХ | 30 | 30 | 0 | 0 | 0 | 100% |
| **9** | БНД НДХ | 2710 | 2664 | 0 | 0 | 46 | 98,3% |
| **10** | НД НДХ | 1676 | 1676 | 0 | 0 | 0 | 100% |
| | *ДҮН* | **12649** | **12378** | **87** | **37** | **271** | **96,8%** |

**2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс НДБ-д хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/**

Хүснэгт 2

| **№** | ***Байгууллагын нэр*** | ***Шийдвэрлэлт*** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт өргөдөл гомдлын тоо | 1800-1200 тусгай дугаар-ын утас | Бичгээр | Засгийн газрын 11-11 төв | Утсаар хандсан | Нутгийн захиргаан ы байгууллагууд | E-service апплик ейшн | Биечлэн уулзсан | Цахим хэлбэрээр |
| **1** | ННДГ | 218 | 58 | - | 72 | - | 69 | 16 | - | 3 |
| **2** | БГД НДХ | 1436 | 5 | 1376 | 2 | - | - | - | 53 | - |
| **3** | ЧД НДХ | 576 | - | 567 | 9 | - | - | - | - | - |
| **4** | БЗД НДХ | 1741 | - | 1706 | 11 | - | - | - | - | 24 |
| **5** | СХД НДХ | 2425 | - | 2425 | - | - | - | - | - | - |
| **6** | СБД НДХ | 623 | | 623 | | | | | | |
| **7** | ХУД НДХ | 1214 | - | 1198 | - | - | 16 | - | - | - |
| **8** | БХД НДХ | 30 | - | 30 | - | - | - | - | - | - |
| **9** | БНД НДХ | 2710 | 1 | 405 | - | 1508 | | | 796 | - |
| **10** | НД НДХ | 1676 | - | 1676 | - | - | - | - | - | - |
| | Нийт | **12649** | **64** | **10006** | **94** | **1508** | **85** | **16** | **849** | **27** |

**2021 оны жилийн эцсийн байдлаар НДБ-д иргэдээс 11-11 төвд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт**

Хүснэгт 3

| | ***Байгууллагын нэр*** | ***11-11 төвөөр*** | ***Тусгай дугаарын утсаар хандсан*** |
|---|---|---|---|
| *1* | ННДГ | 72 | 58 |
| *2* | БГД НДХ | 2 | 5 |
| *3* | ЧД НДХ | 9 | - |
| *4* | БЗД НДХ | 11 | |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | СХД НДХ | - | - |
| 6 | СБД НДХ | - | - |
| 7 | ХУД НДХ | - | - |
| 8 | БХД НДХ | - | - |
| 9 | БНД НДХ | - | 1 |
| 10 | НД НДХ | - | - |
| | *ДҮН* | **94** | **64** |

Хүснэгт 4

| ***Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдлын нийт эзлэх хувь*** |
|---|
| 1.Хүсэлт –**12477**<br>2.Санал **– 4**<br>3.Гомдол **– 165**<br>4.Талархал-**1**<br>5. Мэдээлэл -**2**<br><br>***Агуулгаар нь авч үзвэл:***<br>✓ Тэтгэвэртэй холбоотой асуудлаар – **797буюу 6,30%**<br>✓ Тэтгэмжтэй холбоотой асуудлаар - **259 буюу 2,04%**<br>✓ Илүү тушаасан шимтгэлээ буцаан авах – **1983 буюу 15,6%**<br>✓ ЭМД-ын асуудлаар **– 552 буюу 4,36%**<br>✓ НДШ-ын асуудлаар **– 488 буюу 3,8%**<br>✓ Ажилгүйдлийн тэтгэмжийн асуудлаар – **332буюу 2,62%**<br>✓ Оршуулгын тэтгэмжийн тухай –**205 буюу 1,6%**<br>✓ Жирэмсэн амаржсаны тэтгэмж -**449 буюу 3,9%**<br>✓ Данс андуурсан буруу шилжүүлгийг залруулах тухай – **1368 буюу 10,8%**<br>✓ ХЧТА **-117 буюу 0,01%**<br>✓ Сайн дурын даатгалын тухай- **971 буюу 7,67%**<br>✓ Регистр нэгтгүүлэх асуудлаар **– 273 буюу 2,15%**<br>✓ Тэтгэврээ өөрчлөхөөр хүсэлт гаргасан тухай**- 729 буюу 5,76%**<br>✓ Банкаа өөрчлүүлэх тухай – **221 буюу 1,74%**<br>✓ Итгэмжлэлээр тэтгэвэр авах тухай – **154 буюу 1,2%**<br>✓ Тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотой – **193 буюу 1,52%**<br>✓ Нийгмийн халамжийн тэтгэврийн тухай **-6 буюу 0,04%**<br>✓ НДШ нөхөн төлөх тухай – **64 буюу 0,5%**<br>✓ Тахир дутуугийн тэтгэвэр - **62 буюу 0,49%**<br>✓ Тэжээгчээ алдсаны<br>✓ **-36 буюу 1,28%**<br>✓ Хэлтсийн алба хаагчдаас -**108 буюу 0,85%**<br>✓ Салбарын үйл ажиллагааны тухай – **57 буюу 0,45%**<br>✓ Бусад асуудлаар **-934 буюу 7,38%**<br>✓ Бусад салбарын үйлчилгээний тухай -**55 буюу 0,43%**<br>✓ Мэдээллийн санд залруулга хийх тухай – **51 буюу 0,40%**<br>✓ НДШ давхар төлсөн тухай **291 буюу 2,3%** |

Нийгмийн даатгалын ерөнхий газарт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг өссөн дүнгээр улирлын сүүлчийн сарын 17-ны дотор, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт улирлын сүүлчийн сарын 25-ны дотор өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ тайланг хүргүүлж байна.

## АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 01 өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан хуваарь болон хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу хэлтсүүдээс үүссэн баримтыг архивд хүлээн авч үдэн хавтаслан харьяалагдах тамга тэмдгийг дарж байгууллагын архивын ажлын үндсэн зааврын хавсралт 7-д заасны дагуу хаяглан байршууллаа.

Үүссэн баримтыг байнга, түр, 70 жилийн хадгалах хугацаагаар ангилан хадгаламжийн нэгж бүрдүүллээ. Архивын данс бүртгэлийг шинэчлэн бүртгэлээ. Архивын өрөөний чийг дулааны хэмжигчээр хэмжин тэмдэглэл хийлээ.Улирал тутамд хортон шавж устгах ариутгал мөн чийгтэй цэвэрлэгээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр хийж архивын баримтын хадгалалт, хамгаалалтад болонаюулгүй байдлыг ханган ажиллаа. Албан хаагчдын албан хэрэгцээний хүсэлтийн дагуу шаардлагатай архивын баримтыг албан хэрэгцээнд түр хугацаагаар ашиглуулах бүрдээ гарын үсгийг нь зуруулан тэмдэглэл хөтөлж байна. Баримт бичгийг эх хувиас олшруулан хуулбар үнэн тамгаар баталгаажуулсан баримт бичгийг бүртгэл үйлдэн ажиллаа.

Тус газрын архив Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн 1 давхарт байсныг 3 дугаар давхар луу нүүлгэн шилжүүлэн ажилласан.

Хэлтсүүдийн албан хаагчдаас байнга, түр, 70 н жил хадгалах 97 баримтыг стандартын дагуу үдэж хавтаслан, нүүр бичилт болон баталгааны хуудас дотоод товьёг бүрэн үйлдсэн баримтуудыг архивд хүлээн авсан байна. Нийт 1764 баримт Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн байранд хадгалагдаж байна.

“Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг Газрын даргаар 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлуулан ажилласан байна. Жагсаалтад

- Байнга хадгалах **39**
- Түр хадгалах **50**
- 70 жил хадгалах **8** бөгөөд
- Тамгын хэлтэс **51**
- Санхүү бүртгэлийн хэлтэс **35**
- Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэс **11** н хадгаламжийн нэгжийн жагсаалт боловсруулан ажилласан байна.

## ДОТООД АЖЛЫН ТАЙЛАН

### *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр*

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, гарч болох эрсдэлээс хамгаалах үүднээс PCR түргэвчилсэн шинжилгээнд нийт албан хаагчдыг нэгдсэн журмаар 2 удаа хамруулсан бөгөөд тус бүр хувиараа тухай бүрд PCR шинжилгээнд хамрагдсан. 2021 оны 12 сарын 13-ний байдлаар 20 албан хаагч 3-р тунгийн вакциндаа хамрагдаж урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээгээ авсан бол 3-р тунгийн вакцинаа хийлгээгүй **4,** хийлгэхгүй шалтгаантай **1** албан хаагч байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд нийт албан хаагчдын гэрийн хаяг утасны дугаар, автомашины дугаар, ажилдаа ирж очих замын маршрут зэргийн судалгаа гаргаж ажлын байранд ариутгал халдваргүйтгэлийг “Технологийн инкубатор ХХК”-аар Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамт хийлгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комисс, нийслэлийн онцгой комиссын шийдвэрээр Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх болон ажлын байранд халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах албан хаагчид, бүх нийтийн өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийт ажилтан албан хаагчдыг ээлжийн хуваарьт шилжүүлэн ажиллуулах болон 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж ажиллах тухай газрын даргын нийт **9** удаагийн тушаал гарч тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



НИЙСЛЭЛИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 15 өдөр Дугаар А/05 Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай" 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газарт хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх ажилтнуудын хуваарийг хавсралтаар батлсугай.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан жижүүрийн үүргийг гүйцэтгэх хугацаанд дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн хариуцлагатай жижүүрүүдэд хяналт тавих, мэдээ тайланг авч нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдээлэх, яаралтай арга хэмжээ авч, хариуцлагатай ажиллахыг жижүүрээр томилогдсон ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Тус газрын бусад ажилтан албан хаагчид 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 22-ний өдрийг дуусталх хугацаанд цахимаар буюу зайнаас ажил үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтэс /О.Байгалмаа/-т даалгасугай.

ДАРГА Г.БОЛОРСҮХ

D:\2021\албан бичиг 2021\Тушаал.docx



НИЙСЛЭЛИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 23 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Га[illegible] хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт, Улсын онцгой [illegible] даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ний өрийн 18 дугаар тушаалыг [illegible] ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 202[illegible] оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийг дуусталх хугацаанд ажлын байранд ажиллах албан хаагчдын нэрсийг хавсралтаар [illegible]сугай.

2. Тус газрын 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, ажиллуулахыг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтэс /О.Байгалмаа/-т даалгасугай.

ДАРГА Г.БОЛОРСҮХ

Ковид-19 вирусээс урьдчилан сэргийлэх эрсдэлийг эрт илрүүлэх ухаалаг утсанд суурилсан “КОВИД-19 ЭРСДЭЛ” системийг нийт албан хаагчдын утсанд

суулгаж байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллаа. Энэхүү системийг суулгаж идэвхжүүлснээр 15 минутаас дээш хамт байсан хүмүүсээс хэн нэгний PCR эерэг гарахад 1-р хавьтагч гэдэг мэдээлэл танд очих бөгөөд ингэснээр халдварт өртсөн эрсдэлээ цаг алдахгүй мэдэх, эрт илрүүлэх учирч болох аливаа эрсдэлээс өөрийгөө бүрэн хамгаалах давуу талтай юм.






### *Qr код хяналт шалгалт:*

Нийслэлийн засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 тоот захирамжаар үйл ажиллагааг нь хязгаарлаагүй “Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэх үйл ажиллагааг” зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн харьяа байгууллагууд хяналт тавьж ажиллах хуваарийн дагуу тус газрын 7 албан хаагч 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 07-ний өдөр хүртэл Баянгол дүүргийн 22,23,24-р хороодын **130** аж ахуйн нэгж, хүнсний худалдаа эрхлэгчид үйлчлүүлэгч иргэдийг QR кодоор бүртгэж байгаа эсэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн эсэхэд хяналт тавьж амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, хүн хоорондын зай бариулах халуун хэмжигч гар ариутгагч зэргийг байршуулж ажиллах үүрэг даалгавар өгч ажилласан.







НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021-04-23 Дугаар А/61

Бүх нийтийн бэлэн байдлын үед авах арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн Газраас Коронавируст халдвар/КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгасантай холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн онцгой комиссын шуурхай штаб дээр үүрэг гүйцэтгэх албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэг бүхий Мэдээллийн технологийн төвийн албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус батласугай.

2. Дээрх хугацаанд Нийслэлийн онцгой комиссын шуурхай штаб дээр ажиллахаар томилогдсон албан хаагчдын ажиллах нөхцөл боломж, програм хангамж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд нэвтрэх эрх, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг зохих журмын дагуу хангуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Мэдээллийн технологийн төвийн захирал Г.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын дарга, Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батсүхэд даалгасугай.

ДАРГА Д.ЗОРИГТ



Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд автомашиныг QR кодоор явуулах үйл ажиллагаанд хяналт шалгалтаар ажиллав.
Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/61 тоот тушаалын дагуу НОК-ийн шуурхай штаб дээр тус газрын 13 байцаагч, албан хаагч иргэдэд QR kод олгох ажиллагаанд оролцож, хамтран ажилласан.

НОК-т QR кодоор замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл авахаар хүсэлтээ ирүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн 48618 автомашин эзэмшигчийг регистрийн дугаараар нь тухайн байгууллагадаа ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилладаг эсэхийг нийгмийн даатгалын нэгдсэн лавлагааны программд үндэслэн хянаж, баталгаажуулан ажилласан бөгөөд тухайн байгууллагад шимтгэл төлдөггүй 998 хүний хүсэлтийг буцаан ажиллав.

## *Зах, худалдааны төвийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажиллав*

Худалдаа үйлчилгээний газруудад цагийн хуваарь, халдвар хамгааллын дэглэм, тусгай нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж ажиллах тухай Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрийн баталсан хуваарийн дагуу Хяналт шалгалтын байцаагч Ж.Ганзориг, О.Ууганбаатар, Д.Базарбаатар, Санхүүгийн хэлтэс Б.Санжаасүрэн, Тамгын хэлтэс

И.Пүрэвжав нар батлагдсан хуваарийн дагуу Баянзүрх дүүргийн зах худалдааны төвүүдэд “COVID19 QR verify” аппликэйшнээр үйлчлүүлэгчийн QR кодыг уншуулж, дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан, эсвэл халдвараар өвчлөөд эдгэрсэн тухай магадлагааг шалгаж, нэвтрүүлэх хяналтын ажилтаныг томилж ажиллуулсан эсэх,Ажлын байранд 2 цаг тутамд агаар сэлгэлт хийж, механик агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх
Үйлчлүүлэгч хоорондын зайг 2 метрээс доошгүй байхаар тэмдэг, тэмдэглэгээ хийж, хүний бөөгнөрөл үүсгэхгүй байхад хяналт тавьж буй эсэх зэрэг асуудлуудыг газар дээр шалгаж шалгалтаар илэрсэн дүн мэдээг нэгтгэн тухай бүр мэдээлж ажиллаа.





### *Коронавирус /Ковид-19/ халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллав.*

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Коронавирус /Ковид-19/ халдварын үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллах хуваарийн дагуу Хан-Уул дүүргийн 7,8,9-р хороодын өрхийн эмнэлэг болон дүүргийн дуудлага мэдээлэл төвд ээлжийн хуваарийн дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэж ажиллав.

### *Бүх нийтээр мод тарих өдөрлөг*

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн хүрээнд “Мод тарих үндэсний өдөр” 2021 оны 05 сарын 08-нд тохиосон.
Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед олон нийтийг хамарсан байдлаар мод тарих үйл ажиллагааг зохион байгуулахгүй тул Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31,1-т заасны дагуу мөнгөн хандивыг 1 албан хаагчийн 5000 төгрөгөөр тооцон НБОГ-ын төрийн сангийн 100200000907 тоот дансанд мөнгөн хандивыг шилжүүлэв.

**ХААН БАНК**

Огноо/Date: **2021.05.14 15:59:01**

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: **915582406**

Системийн огноо/System Date: **2021.05.14**

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дт** | Дансны/Картын дугаар<br>Account/Card number<br>**5070 033 118** | Нэр/Name<br>**ИШЖАМЦ ПҮРЭВЖАВ** | Дүн/Amount<br>**115,000.00 MNT** | Ханш/Rate<br>**1.00** |
| | **/ нэг зуун арван таван мянган төгрөг /** | | | |
| **Кт** | Банкны дугаар/Branch No<br>**90**<br>Дансны/Картын дугаар<br>Account/Card Number<br>**100200000907** | Банкны нэр/Bank Name<br>**Төрийн Сан**<br>Нэр/Name<br>**НБОГ. ангилагдаагүй бусад орлого** | **115,000.00 MNT** | **1.00** |

Гүйлгээний утга/Transaction description:
**EB-ннлг-аас мод тарих үндэсний өдөрлөгт**

### *Ахмадуудад хүндэтгэл үзүүлэв.*

Тус газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан 15 ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан тус газрын 26 албан хаагчдын 51 хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлж хүүхдийн баярын бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулав.

Мөн Нийслэлийн засаг даргын гарын бэлгийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан БЗД-н 20-р хорооны өндөр настан Д.Ишханд, БЗД-н 28-р хорооны өндөр настан Д.Лааганжав зэрэг 5 хүнд гардуулж өгөх үүргийг хүлээж хяналт шалгалтын байцаагч Д.Базарбаатар, М.Номинчимэг нар гэрийн хаягаар нь хүргэж өгч гардуулж өгөв.











Ахмадууд маань Ерөнхийлөгчийн бэлэг өчигдөр ирсэн өнөөдөр Нийслэлийн засаг даргынх ирлээ. Маргааш дүүргийн засаг даргын гарын бэлэг ирэх байх даа хэмээн баяр хөөртэй инээж суусан гэнэ лээ.

### *Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III*

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III /2020-2024/-ын хэрэгжилтийг үнэлж дүгнэх цаашид монгол бичгийн талаар төрөөс авч хэрэгжүүлэх, бодлого дүрэм журам, үндсэн чиглэл боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болгоход чиглэгдсэн Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд тус газрын 25 албан хаагч хамрагдсан.

Мөн НДЕГ-аас профессор Г.Буянтогтох багштай хамтран танхим болон цахим хослуулан явуулсан монгол бичгийн цахим хэрэглээ, монгол бичгээр албан хэрэг хөтлөн явуулах 2 сарын хугацаатай сургалтад тус газрын 18 албан хаагч хамрагдаж сургалтын дараах сорилыг амжилттай өгч Гэрчилгээ гардан авсанаар 2022 оноос эхлэн кирилл монгол бичгээр төрийн байгуулллагын албан хэргээ хөтлөн явуулах бэлтгэл ажил хангагдаж байна.












*“Өгөөмөр өдөр” үйл ажиллагаа*

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг өөрт хэрэггүй зүйлсээ хэрэгтэй нэгэндээ өгөх солилцох “Өгөөмөр өдөр” арга хэмжээ 2021 06 дугаар сарын 18-27-ний өдрүүдэд Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа бөгөөд уг арга хэмжээнд идэвхтэй оролцохыг уриалж бүх албан хаагчдад зарыг хүргээд байна.



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Т.ГАНТӨМӨР

ӨӨРТ ХЭРЭГГҮЙ ЭД ЗҮЙЛСЭЭ ХЭРЭГТЭЙ НЭГЭНДЭЭ ӨГӨХ, СОЛИЛЦОХ "ӨГӨӨМӨР ӨДӨР" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2021 оны 06 дугаар сарын 11 Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ, иргэд хамрагдана.

ГУРАВ. ХУГАЦАА

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




## *Спортын арга хэмжээ*

Нийслэлийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, дархлааг дэмжих зорилгоор “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг 2021 оны 06 дугаар сарын 02-30 өдрүүдэд алхалт, гүйлт, дугуй унах хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд Уг арга хэмжээнд тус газрын албан хаагчид утсандаа STRAVA аппликейшныг суулгаж цахим хэлбэрээр оролцож байгаа бөгөөд өдөр болгоны мэдээгээ нутгийн захиргааны гүйгчид 2021 страва аппликейшн группэд оруулж 7 хоногоор мэдээг нэгтгэж үзэхэд 44-122 км алхаж дугуй унасан байна.




Автозамын түгжрэлээс шалтгаалан иргэдийн унадаг дугуй унах нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа тул дугуйтай ажилдаа ирсэн албан хаагчдадаа урамшуулж, өглөөний цайгаар дайлдаг байх, унадаг дугуйтай ирсэн үйлчлүүлэгч иргэдэд зориулсан стандартад нийцсэн унадаг дугуйн зогсоолтой байхыг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд уриалж ажиллаа.

### *Нэг албан хаагч-нэг цэцэг арга хэмжээ зохион байгуулав*

Ажлын байрандаа ногоон орчин бүрдүүлж нэг албан хаагч нэг цэцэг аян өрнүүлж өрөө тасалгаандаа цэцэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа.





### *"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-д нэгдэв*

Жил бүрийн 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гариг буюу мод тарих үндэсний өдрөөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын албан хаагчид Налайх дүүргийн 7 дугаар хороо, Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 160 гаруй “Голт бор” мод тарилаа.






## *Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагаа*

Байгууллагын дэргэд газрын даргын тушаалаар Эцэг эхийн зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөл, спорт хамтлаг зэрэг дотоод ажил зохион байгуулалтын нэгжүүдтэй бөгөөд Монгол улсад залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний түүхэт 100 жилийн ойн хурал болон улсын хэмжээнд зохион байгуулагдсан Залуучуудын зөвлөлийн цахим уулзалтад оролцож байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл байгуулагдсан тухай, зөвлөлийн бүтэц орон тооны талаар https://www.ydc.mn/zxz/#/login сайтад бүртгүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж ажиллаа. Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Соёлын яамтай хамтран зохион байгуулж буй байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн зөвлөгөөнд оролцов.

## *Спортын арга хэмжээ*

Нийслэлийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, дархлааг дэмжих зорилгоор “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг 2021 оны 06 дугаар сарын 02-30 өдрүүдэд алхалт, гүйлт, дугуй унах хэлбэрээр зохион байгуулсан.

Тус газрын албан хаагчид утсандаа STRAVA аппликейшныг суулгаж цахим хэлбэрээр оролцож өдөр болгоны мэдээгээ нутгийн захиргааны гүйгчид 2021 страва аппликейшн группэд оруулж 7 хоногоор мэдээг нэгтгэж хүргүүлж ажиллаа. Тамгын хэлтсийн Сургалт, сурталчилгаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав унадаг дугуйн төрөлд 542,04 км зам туулсан үзүүлэлтээр чингэлтэй дүүргийн



хэмжээнд тэргүүн байрт шалгарсан байна.







*Ургац хураалт 2021 арга хэмжээ*

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын албан хаагчид "Ургац хураалт 2021" арга хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 17-19 ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант суманд Төмс хураалтын ажилд оролцлоо.



## ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТООН МЭДЭЭ, ТАЙЛАН

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ /тэрбум төгрөгөөр/**

Нийгмийн даатгалын сангийн орлого

1 218,6



1 068,4 | 71,9 | 64,4 | 13,8

Нийгмийн даатгалын сангийн зарлага

1 080,2



940,9 | 92,6 | 11,9 | 34,8



Ажил олгогчийн тоо

33909



Албан журмын даатгуулагчийн тоо

672252



Сайн дурын даатгуулагчийн тоо

68862

| Өндөр настны тэтгэвэр | Тахир дутуугийн тэтгэвэр | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | Цэргийн тэтгэвэр | ҮОМШӨ-ний ТД, ТА тэтгэвэр |
|---|---|---|---|---|
| 145006 | 24011 | 7298 | 12382 | 1918 |



| ХЧТА тэтгэмж авагчид | Жирэмсэн амаржсаны тэтгэмж авагчид | Оршуулгын тэтгэмж авагчид | Ажилгүйдлын тэтгэмж авагчид |
|---|---|---|---|
| 102890 | 34701 | 7010 | 15452 |

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019-2020 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААРХ ОРЛОГО ЗАРЛАГА






Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт2021оны эхний 11 сарын байдлаар нийт орлого 1218,6 тэрбум төгрөг, зардалд1080,2 тэрбум төгрөг зарцуулсныг өмнөх онтой харьцуулж үзэхэд орлого 436,6 тэрбум төгрөгөөр буюу 55,8 хувиар өссөн бөгөөд зардал67,2 тэрбум төгрөгөөр буюу 6,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.






# ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН

Тэтгэврийн даатгалын сангаас 2021 оны 11 дүгээрсарын байдлаар өндөр нас, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 188697 иргэдийн тэтгэвэрт 940,86 тэрбум төгрөг зарцуулж, нийт тэтгэвэр авагч иргэдийн тоог өмнөх онтой харьцуулж үзэхэд 5841 тэтгэвэр авагч буюу3,2 хувиар, зарцуулсан хөрөнгө нь54,04 тэрбум төгрөг буюу6,09 хувиар тус тус өссөн байна.

| Тэтгэврийн төрөл | 2019 оны 4-р улирал | | 2020 оны 4-р улирал | | 2021 оны 4-р улирал | |
|---|---|---|---|---|---|---|
| | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ |
| Өндөр насны | 130 111 | 584 211,1 | 139 094 | 685 925.6 | 145 006 | 733 919,84 |
| Тахир дутуугийн | 24 396 | 76 374,9 | 24 546 | 85 349.2 | 24 011 | 85 724,52 |
| Тэжээгчээ алдсаны | 7 224 | 23 295,2 | 7 091 | 25 762.9 | 7 298 | 26 340,26 |
| Цэргийн | 11 903 | 82 961,4 | 12 125 | 89 779.0 | 12 382 | 94 874,04 |
| **Нийт** | **130 111** | **766 842,6** | **182 856** | **886 816.7** | **188 697** | **940 858,66** |

# ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

Тэтгэмжийн даатгалын сангаас 2021 оны 11 дүгээрсарын байдлаар 144 601даатгуулагчдад 92,66 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж

олгов.Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,72тэрбум төгрөг буюу 13,08хувиар өссөн байна.

| Тэтгэмжийн төрөл | 2019 оны 4-р улирал | | 2020 оны 4-р улирал | | 2021 оны 4-р улирал | |
|---|---|---|---|---|---|---|
| | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ |
| Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж | 74 165 | 11 498,8 | 63 151 | 12 009.6 | 102 890 | 16 462.62 |
| Жирэмсний болон амаржсаны тэтгэмж | 34 201 | 52 821,3 | 33 563 | 64 238.8 | 34 701 | 68 266.09 |
| Оршуулгын тэтгэмж | 5 307 | 5 306,6 | 5 068 | 5 076.0 | 7010 | 7010.00 |
| **Дүн** | **113 673** | **69 626,7** | **101 782** | **81 324.4** | **144 601** | **91 738.71** |

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны,жирэмсний болонамаржсаны тэтгэмжид зарцуулсан хөрөнгө /тэрбум төгрөгөөр/









# ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН

2021 оны 11дүгээрсарын байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 1918 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 11.5 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 344 даатгуулагчийн тэтгэмжид 334.64 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон рашаан сувиллын зардалд 79.34 сая төгрөг зарцуулсан байна. Зардал өмнөх оны мөн үеийнхээс 337.89сая төгрөгөөр буурсанбайна.

| ҮОМШӨ-ний даатгалын сан | 2019 оны 4-р улирал | | 2020 оны 4-р улирал | | 2021 оны 4-р улирал | |
|---|---|---|---|---|---|---|
| | Даатгуу-лагчийнтоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуу-лагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуу-Лагчийн тоо | Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/ |
| Тахир дутуугийн тэтгэвэр | 1 823 | 10 324,5 | 1 774 | 10 442.0 | 1 730 | 10 332.63 |
| Тэжээгчээ алдсаны | 205 | 1 054,4 | 194 | 1 122.7 | 188 | 1 132.89 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| тэтгэвэр | | | | | | |
| | | | | | | |
| Тэтгэмж төлбөрийн | 545 | 413,8 | 502 | 457.9 | 344 | 334.64 |
| | | | | | | |
| | | | | | | |
| Хиймэл эрхтэн, протез | | | | | | |
| Рашаан сувиллын зардал | 1003 | 245,6 | 721 | 194.7 | 253 | 79.34 |
| | | | | | | |
| | | | | | | |
| **Дүн** | **3 576** | **12 038,3** | **3 191** | **12 217,3** | **2 515** | **11 879,5** |
| | | | | | | |

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ҮОМШӨ-НИЙ 2019-2021 ОНЫ ОРЛОГО ЗАРЛАГА**




# АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

2021 оны 11 дүгээрсарын ажилгүйдлийн даатгалын сангаас 15452 даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид 34786,93 сая төгрөг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо урьд оноос 2883даатгуулагчаар өсч, зардал нь 2 762,72сая төгрөгөөр өссөнүзүүлэлттэй байна.

| Ажилгүйдлийн | 2019 оны 4-р улирал | | 2020 оны 4-р улирал | | 2021 оны4-р улирал | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |

| даатгалын сан | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/ | Даатгуулагчийн тоо | Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| Ажилгүйдлийн тэтгэмж | 13 706 | 28 000,4 | 12 569 | 32 024,2 | 15 452 | 34 786,9 |
| | | | | | | |
| | | | | | | |
| **Дүн** | **13 706** | **28 000,4** | **12 569** | **32 024,2** | **15 452** | **34 786,9** |
| | | | | | | |

**АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО ЗАРЛАГА**




**Нийслэлийн хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2018-2020 оны 4-р улирлын байдлаар харьцуулан харуулбал**

**/Тэрбум төгрөг/**

| Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага | 2019 оны 4-р улирал | 2020 оны 4-р улирал | 2021 оны 4-р улирал |
|---|---|---|---|
| | **107 400,6** | **157 860,7** | **276 097,8** |
| **Дүн** | **107 400,6** | **157 860,7** | **276 097,8** |

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага урьд оноос 118,2 тэрбум төгрөгөөр буюу 74,9 хувиар өссөн байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

**Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг дүүргээр нь харуулбал:**

**/ тэрбумтөгрөгөөр/**

| Дүүргүүдийн нэр | 2020 оны 4-р улирал | 2021 оны 4-р улирал | Зөрүү |
|---|---|---|---|
| Чингэлтэй | 18 271,2 | 29 093,9 | +10 822,7 |
| Сонгинохайрхан | 9 180,2 | 21 462,9 | +12 282,7 |
| Баянгол | 18 027,7 | 38 514,4 | +20 486,7 |
| Хан-Уул | 32 114,2 | 55 485,2 | +23 371,0 |
| Баянзүрх | 31 710,8 | 49 889,6 | +18 178,8 |
| Сүхбаатар | 40 945,7 | 69 163,8 | +28 218,1 |
| Багануур | 6 871,9 | 10 831,4 | +3 959,5 |
| Налайх | 589,6 | 1 381,9 | +792,3 |
| Багахангай | 149,4 | 274,6 | +125,2 |
| Нийт дүн | 157 860,7 | 276 097,8 | 118 237,1 |

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг өмнөх оныг мөн үетэй харьцуулан дүүрэг тус бүрээр нь үзэхэд дунджаар 13,1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**2021 оны эхний 11 сарын байдлаар авлагын насжилтыг хувиар болон тэрбум төгрөгөөр харуулбал.**




| Авлагын насжилт | Авлагын дүн (тэрбум. төгрөг) |
|---|---|
| 0-30 хоног | 15,9 |
| 31-60 хоног | 17,3 |
| 61-90 хоног | 14,1 |
| 91-120 хоног | 16,2 |
| 121-ээс дээш | 90,8 |
| Нийт | 154,5 |

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг насжилтаар нь харуулбал 50,5 хувь буюу 139,5 тэрбум төгрөгийг 121 хоногоос дээш авлага, 16,6 хувь буюу 46,1 тэрбум төгрөгийг 91-120 хоногтой авлага хамгийн өндөр хувийг эзэлж байна.

# НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ 11САРЫН МЭДЭЭНИЙ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Үйл ажиллагааны орлого/ сая төгрөгөөр/




Нийгмийн даатгалын сангаас урсгал санхүүжилт нийт 7 322.90 сая төгрөг байгаагаас цалин хөлс болон нэмэгдэл 5 404.10 сая төгрөг буюу 74%, ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл 719.38 сая төгрөг буюу 10%, бусад орлого 1 199.42 сая төгрөг буюу 16%-г тус тус эзэлж байна.

## Үйл ажиллагааны зарлага/ сая төгрөгөөр/




Нийт зардлын дүн 6 902.92 сая төгрөг байгаагаас цалин хөлс нэмэгдэл 5 182.88 төгрөг буюу 75%, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 701.06 сая төгрөг буюу 10%, бусад зардалд 1 018.98 сая төгрөг буюу 15%-ийг тус тус эзэлж байна.

## Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын 2019-2021 оны 4-р улирлын байдлаарх бүтэц, орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл




2021 оны 4 дүгээр улирлын хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын орон тоон төлөвлөгөө 433 байгаагаас гүйцэтгэл нь 431 байна.

## Нийт өглөг

/сая төгрөгөөр/




2021 оны 11 сарын байдлаар нийт өглөг 49.04 сая төгрөг байгаагаас хувь хүний орлогын албан татварын өглөг 3.50 сая төгрөг буюу 7 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 43.19 сая төгрөг буюу 88хувь, бусад өглөг 2.35 сая төгрөг буюу 5хувийг эзлэж байна.

## Санхүүгийн тайлан, мэдээ гаргалтын талаар

Нийслэлийн дүүргүүдийн нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн болон үйл ажиллагааны, нэгдсэн санхүү төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 4 дүгээр улирлын тайлан гаргах бэлтгэл ажлыг хангуулж, мэргэжил арга зүйгээр ханган, тайлан гаргахад анхаарах асуудал, тайлан ирүүлэх хуваарийг хүргүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн дагуу дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн сангийн болон үйл ажиллагааны, нэгдсэн санхүү, төсвийн гүйцэтгэлийн 2020 оны жилийн эцэс, 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг тойрох хуудасны дагуу баталгаажуулан, хүлээн авч, хянан нэгтгэж, нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 2020 оны жилийн эцсийннэгтгэсэн санхүүгийн тайлан **“Мэдээлэл аудит”** ХХК-д хуулийн дагуу хүргүүлж, 2020 оны жилийн эцсийн болон 2021 оны 2 дугаар улирлын нэгтгэсэн санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны **“Э-ТАЙЛАН”** программд дүүрэг тус бүрээр шивж оруулан хянаж нягтлан баталгаажуулсан.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл, сангийн авлага, өглөгийн 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 1-11 дугаар сарын мэдээнүүдийг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн мэдээнүүд, холбогдох судалгааг Нийслэлийн статистикийн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаа.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан дүн шинжилгээ хийж сар бүр цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, сарын мэдээ хэмнэлт хэтрэлтийн тайлбар, нийгмийн даатгалын сангуудын сарын мэдээг файл үүсгэн НДЕГ-аас олгодог санхүүжилт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын батлагдсан жилийн төсөв дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүрт нь, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг /www.shilendans.ub.gov.mn/шилэн дансны web хуудсанд цаг тухай нь байршуулан ажилласан.

Нийслэлийндэх аудитын газраас Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцсэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гэж **“Зөрчилгүй”** стандарт дүгнэлт авч ажилласан.Мөн 2020 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын захиалгаар Мэдээлэл аудит ХХК аудит хийж, акт, албан шаардлага, зөвлөмж ирүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг цаг хугацаанд нь гарган хүргүүлэн ажилласан.

“Мэдээлэл аудит” ХХК-аас ирүүлсэн Аудитын гэрчилгээ, аудитын дуусгавар болгосон тухай тайлан, менежментийн захидал, аудитын байгууллагад хүргүүлсэн менежментийн захидлын хариуны хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

## Хэлтсийн дотоод ажлын талаар

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны зардлын 2021 оны батлагдсан төсвийн 558 147 500 төгрөгийн үйл ажиллагааны урсгал санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зардлын төрлөөр зарцуулан ажилласан.

Мөн нэмэлт 7 000 000 төгрөгийн санхүүжилтээр иргэд, даатгуулагч, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх,хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэл, зарлага, өр авлагын дэлгэрэнгүй мэдээг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, ахлах нягтлан бодогч-ахлах мэргэжилтнээр хянуулж, хэлтсийн дарга болон газрын даргад танилцуулж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 1-12дугаар сард гарсан аж ахуй материал, бичиг хэрэг, шатах тослох материалын зардлын тооцоог холбогдох байгууллага ажилтантай тооцоо хийж, анхан шатны баримтыг үндэслэн тайлангцаг тухайд нь гарган ажиллаж байна.

2020 оны жилийн эцэс, 2021 оны 1-12дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийнтайланг гаргаж Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд тайлагнаж хүргүүлсэн.

Нийслэлийн татварын газар болон Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй 2020 оны жилийн эцэс болон 2021 оны 1-ээс 3дугаар улирлын хувь хүний орлогын албан татвар болон суутган тооцооллыг гаргаж тооцоо нийлсэн акт үйлдэж татварын үлдэгдлийг баталгаажуулан өр авлагагүй ажиллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлого хэрэгжилт, судалгааны газарт ННДГ-ын ажилтнуудын цалин хөлсний нэмэгдлийн судалгааг гаргаж хүргүүлсэн.

Үндсэн хөрөнгийн тооллого хийх тухай газрын даргын тушаал гарч, өр авлага, өмч хариуцсан мэргэжилтэн Б.Санжаасүрэн нь ажилчдын хөрөнгийн картыг шинэчлэн тооллогын комиссын дарга болон гишүүд, газрын нийт албан хаагчдаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд 2020 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг оруулж ажилласан.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлангаар орлого, зарлагын гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, санхүүгийн тайланд өглөг, авлагын үлдэгдлийг бүрэн тусгуулах, төсвийн гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг

сайжруулах зэрэгт 2020 оны жилийн эцсийн тайлангийн дүн, 2021 оны 2-р улирлын тайлангийн дүнд дүүрэг тус бүрээр дүн шинжилгээ хийж нийгмийн даатгалын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Санхүү бүртгэлийн хэлтэс нь 2020 оны нэгтгэсэн санхүүгийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын сан, үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны харилцахын баримт, аж ахуй, бичиг хэрэг, шатахуун, сэлбэг хэрэгслийн тайлангуудыг нэгтгэж нийт 73 боть баримтыг архивын нэгж бүрдүүлэн архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгч, архивын нэгж бүрдүүлэн ажилласан.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ний өдөр гарсан 01 албан даалгаврын дагуу нийгмийн даатгалын авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд их хэмжээний шимтгэлийн өртэй ажил олгогчтой биечлэн уулзах, график байгуулах, дансны зарлагын гүйлгээг түр хаах, шүүхэд өгөх зэрэг шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2021 оны 10 дүгээр сарын 01-ны өдөр баталсан удирдамж

ийн дагууСанхүү бүртгэлийн хэлтсийн дарга С.Ундармаа ахалж, хүний нөөцийн мэргэжилтэн, хуулийн зөвлөх Л.Гэрэлмаа, Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл тайлан хариуцсан мэргэжилтэн Э.Сумьясүрэн, өмч хариуцсан мэргэжилтэн Б.Санжаасүрэн нар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомж, Засгийн газрын 2019 оны 472, 275 дугаар тогтоол болон санхүүгийн бүртгэлийн чиглэлээр гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилт, хэлтсийн үйл ажиллагааны зардлын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэл, бүрдэлтийг хянаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн 2019, 2020 он болон 2021 оны хагас жилийн санхүүгийн баримтыг шалган илэрсэн зөрчил дутагдлыг арилгах тал дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Мөн 2021 оны 11 дүгээр сарын 08-аас 12-ны өдрийг дуустал хугацаанд нийслэлийн төвийн зургаан дүүргээр Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн дарга Л.Очирбал Санхүү бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч ахлах мэргэжилтэн М.Цандмаа, өр авлага хариуцсан мэргэжилтэн Б.Солонго, нар ковид-19 цар тахал халдварт өвчлөлийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийн материал нэмэгдсэнтэй холбоотой иргэдээс ирсэн санал гомдлыг

үндэслэн тэтгэмжийн зардлыг цаг тухайд нь олгож байгаа эсэхэд хяналт тавьж заавар зөвлөгөө өгөн ажилласан

**Газрын үйл ажиллагаатай холбоотой хийсэн ажил**

2021онд батлагдсан төсвийн дагуу ажилчдын цалин, тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлын гүйлгээг хийж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүр гарган Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн орлого, шимтгэлийн байцаагчид цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны болон Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс тогтоосон хуваарийн дагуу батлагдсан маягтаар дүүрэг тус бүрээр хүлээн авч хянаж, шалган нэгтгэж, тайлбар танилцуулгын хамт хэлтсийн болон газрын даргад танилцуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын бодлогын хэрэгжилт, судалгааны газарт 2021 оны 07 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлсэн.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх, зээл аваагүй тэтгэвэр авагчид 1,0 сая төгрөгтэй тэнцэх дүнтэй үнэт цаасыг эзэмшүүлэх, тэтгэвэр барьцаалсан зээлтэй иргэний зээлийн үлдэгдэл төлбөр нь 1,0 сая төгрөгийн хэмжээнээс бага байвал зөрүү төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээний үнэт цаасыг олгох ажлыг зохион байгуулж Нийслэлийн хэмжээнд тэтгэврийн зээлгүй 92579 үнэт цаас,  1,0 сая төгрөгийн хэмжээнээс бага тэтгэврийн зээлтэй 17401 үнэт цаас нийт 109980 үнэт цаасыг харьяа дүүргийн дагуу ангилан дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгсөн. Мөн тэтгэвэр авагчдад үнэт цаас олгох ажилд хяналт тавьж ажиллаа.

“Тэтгэвэр авагчдад олгох үнэт цаасны тухай”



## ГУРАВ.ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс нь хэлтсийн дарга болон хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч-2, нийгмийн даатгалын улсын

байцаагч-10 нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр хяналт шалгалт, дотоод аудитын ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Тус хэлтэс нь 2021 онд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, туслан зааварчлах, өр авлагын барагдуулалтад хяналт тавих, иргэд даатгуулагчдын санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, даатгуулагчдын хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд ажлаа төлөвлөж гүйцэтгэлийг хангаn ажиллалаа.

## НЭГ. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

### 1.1 ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

**1.1.1.** Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн 2021 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу “Тэтгэвэр олголтын хяналтын програм”-д тусгагдсан нас барснаас хойш тэтгэвэр илүү олгосон, давхар тэтгэвэр авдаг, тэтгэврийн нас буруу, харъяатаас гарсан гэсэн 4 үзүүлэлтээр дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны 01-12, 2021 оны 01 сарын мэдээллийг хамруулан 2021 оны 01 дүгээр сарын 15-наас 28-ны хооронд мэдээллийн баазад тулгуурлан цахим хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар нийслэлийн хэмжээнд нийт 154 иргэнтэй холбоотой 191,4 төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын байдлаар байдлаар шалгалтаар илэрсэн нийт төлбөр зөрчлийн 80 хувь буюу 153,1 сая төгрөгийг барагдуулж ажилласан.

Шалгалтын мөрөөр дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хяналт шалгалтын ажлын хүрээнд гаргасан “Зөвлөмж” болон 2021 оны 03 дугаар сарын 01-ний “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 08 тоот тушаалаар шалгалтаар илэрсэн зөрчлийг бүрэн барагдуулах, дотоодын хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлж алдаа дутагдалгүй ажиллах хугацаатай үүрэг өгч ажиллаа.

**1.1.2.** Батлагдсан удирдамжийн дагуу дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны тэтгэврийн олголтод нэгдсэн мэдээллийн баазад тулгуурлан 2021 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийг дуусталх хугацаанд цахим хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.Шалгалтад дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн нийт 196977 тэтгэвэр авагч хамрагдсан бөгөөд үүнээс зөрчилтэй байх магадлал бүхий 3302 тохиолдлыг түүвэрлэн авч тэтгэврийн олголтыг шалгасан.

Шалгалтаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст 2014-2020 онд тэтгэвэр авах эрхийн харилцаа дуусгавар болсон боловч програмд зогсоох хөдөлгөөн хийгээгүйн улмаас тэтгэвэр авагчдын жагсаалт /массив/-д хуучин хөдөлгөөнтэй байгаа 403, 2016-2019 онд нас барсан боловч мэдээллийн баазаас хасагдаагүй 979 иргэний зөрчил болон 81 хүнд 6465708 төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчилтус тус илэрсэн. Илэрсэн зөрчлийг шалгалтын явцад бүрэн барагдуулж ажилласан болно.

**1.1.3.** 2021 оны 05 дугаар сард дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн үндэслэлийг шалгах ажлыг зохион байгуулж ажиллав.

Шалгалтаар хуурамч баримт бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгосон 82 иргэнд холбогдох 1665,1 сая зөрчил илэрсэн. Жилийн эцсийн байдлаар18 иргэний 411,4 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд буцаан төлүүлсэн болно.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулах, цаашид хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоохдоо анхаарах асуудлын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

## 1.2. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

**1.2.1.**Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын өгсөн үүргийн дагуу Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн нийгмийн даатгалын сангийн бусад авлага, өглөгийн дансны бүртгэл, анхан шатны баримт бүрдүүлэлтэд хийх хяналт шалгалтыг 2021 оны 06 сарын 01-ний өдрөөс 06 сарын 30-ныөдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Шалгалтаар залруулгын гүйлгээтэй холбоотой 19,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллаа.

**1.2.2.** Батлагдсан удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сангийн тайланд тусгагдсан бусад авлага 1218, бусад өглөгийн 3303 дансны гүйлгээ, бүртгэлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацааг хамруулан 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 09 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаа.

Шалгалтаар нийгмийн даатгалын сангийн данснаас холбогдолгүй хувь хүн дээр ногдуулсан, хамааралгүй байгууллагын данс руу шилжүүлсэн, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн илүү төлөлттэй кредитийн мөнгөөр байгууллагын бусад авлагыг хаасан, сайн дурын даатгалын илүү төлөлтийг шилжүүлэн тооцож залруулаагүй 1761 хүний 1,157,308,476.00 төгрөгийн зөрчилтэй гүйлгээ,оны эцсийн илүү төлөлттэй буюу кредит үлдэгдэлтэй 3123 ажил олгогч даатгуулагчийн нийт 30,267,847.00 төгрөгийн кредит бууруулж, сангаас үндэслэлгүй 7,285,000.00 төгрөг шилжүүлсэн, улсын байцаагчийн актын өглөгийг олгоогүй,үндэслэлгүйгээр тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон 15,377,681.00 төгрөг,сангаас нөхөн төлүүлэх 34 хүний 14,820,847.00 төгрөгийн төлбөр нийт 3123 ажил олгогч 1799 хүний 1,255,059,851.00 төгрөгийн зөрчил гарсан.

Шалгалтын мөрөөр тус хэлтэст хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулаххугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажилласан.

## 1.3. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

**1.3.1.**Батлагдсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн

тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг шалгасан байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн.

Шалгалтад Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн хөдөлмөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон нийт 1943 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг хамруулж, үүнээс эрсдэлтэй байх магадлалтай 106 хувийн хэргийг түүвэрлэн авч мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, анхан шатны баримтад тулгуурлан шалгав.

Шалгалтаар хуурамч баримт бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгосон 20 иргэнд холбогдох 494,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж ажиллав. Жилийн эцсийн байдлаар 2 иргэнд холбогдох 12,1 сая төгрөгийг барагдуулж ажиллав.

**1.3.2.**Батлагдсан удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын хэрэгжилт болонхөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг шалгасан байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

## ХОЁР. ГАДААД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Нийслэлийн хэмжээнд батлагдсан удирдамж болон иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу 549 ААНБ-д нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж хяналт шалгалт хийж нийт 537 аж ахуйн нэгж, байгууллагад 474,4 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 2021 оны 12 дугаар сарын байдлаар актын төлбөрийг 100 хувь барагдуулж ажилласан. 12 аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан тухай “Зааварчилгаа” хүргүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Дүүрэг тус бүрээр харуулбал:

БГД-ийн НДХ-136 аж ахуйн нэгж, байгууллагад 102,2 сая төгрөгийн,

БЗД-ийн НДХ-56 аж ахуйн нэгж, байгууллагад 63,2 сая төгрөгийн,

СХД-ийн НДХ-24 аж ахуйн нэгж, байгууллагад 24,2 сая төгрөгийн,

СБД-ийн НДХ-19 аж ахуйн нэгж, байгууллагад 33,1 сая төгрөгийн,

ХУД-ийн НДХ-151 аж ахуйн нэгж, байгууллагад 70,1 сая төгрөгийн,

ЧД-ийн НДХ-140 аж ахуйн нэгж, байгууллагад 175,0 сая төгрөгийн,

БНД-ийн НДХ-9 аж ахуйн нэгж, байгууллагад 5,7 сая төгрөгийн,

НД-ийн НДХ-2 аж ахуйн нэгж, байгууллагад 0,9 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тус тус тогтоосон байна.

## ГУРАВ. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтны судалгааг гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болон Нийслэлийн Прокурорын газарт хүргүүлэн ажилласан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч нарт цахим сургалт зохион байгуулж, мэдээллээр хангаж, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

Нийслэлийн хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 333 аж ахуйн нэгж, байгууллагад 95,2 сая төгрөгийн торгууль оногдуулж, торгуулийн төлбөрийг бүрэн барагдуулж ажилласан байна.

Дүүрэг тус бүрээр харуулбал:

БГД-ийн НДХ-36 аж ахуйн нэгж, байгууллагад 9,9 сая төгрөгийн,

БЗД-ийн НДХ-63 аж ахуйн нэгж, байгууллагад 12,0 сая төгрөгийн,

СХД-ийн НДХ-33 аж ахуйн нэгж, байгууллагад 8,9 сая төгрөгийн,

СБД-ийн НДХ-111 аж ахуйн нэгж, байгууллагад 36,2 сая төгрөгийн,

ХУД-ийн НДХ-30 аж ахуйн нэгж, байгууллагад 6,1 сая төгрөгийн,

ЧД-ийн НДХ-52 аж ахуйн нэгж, байгууллагад 20,4 сая төгрөгийн,

НАД-ийн НДХ-3 аж ахуйн нэгж, байгууллагад 0,7 сая төгрөгийн,

БНД-ийн НДХ-5 аж ахуйн нэгж, байгууллагад 0,7 сая төгрөгийн торгууль тус тус оногдуулсан байна.

## ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР

**4.1.**2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 206 тоот тогтоолын дагуу Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтэд үнэлгээ, хяналт-шинжилгээ хийв.

2021 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын тогтоол 1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал 3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал 16, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамж 1, нийт 20 тогтоол, шийдвэрийн заалтыг хяналтад авсан байна.

Хяналтад авсан 20 тогтоол шийдвэрийн 16 (80 хувь) нь бүрэн биелэгдсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 4 (20 хувь) заалт хэрэгжиж байгаа 84,7 хувийн үнэлгээтэй, биелэлтийн дүн дунджаар 96,95 хувьтай үнэлэгдэв.

Засгийн газрын 1 тогтоол шийдвэр бүрэн хэрэгжсэн, 100 хувийн үнэлгээтэй.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 3 тушаал шийдвэр бүрэн хэрэгжсэн 100 хувьтай;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 16 тушаалын 12 тушаал бүрэн хэрэгжсэн, 4 тушаал хэрэгжиж байгаа бөгөөд биелэлт 84,7 хувьтай;

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 1 захирамж бүрэн хэрэгжсэн 100 хувьтай байна.

Үнэлгээ хийхдээ тогтоол, шийдвэрийн хэрэгжиж дуусах хугацаа болоогүй, цаашид хэрэгжих заалтуудыг хэрэгжиж байгаа ангилалд оруулан үнэлгээ өгсөн болно.

**4.2.** 2021 оны жилийн эцсийн байдлаар тус газарт хандаж ирүүлсэн, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдалд шинжилгээ-үнэлгээ хийлээ.

2021 оны 6 дугаар сарын 01-ний байдлаар:
1. 18001200 тусгай дугаарт- 58
2. Гар утасны аппликейшнээр- 3
2. Засгийн газрын 1111 төвд- 72
3. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд- 3
4. Нутгийн захиргааны байгууллагаар- 66
5. Check my service аппликейшн- 16
нийт 218 өргөдөл гомдол ирсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:
1. Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо- 218
2. Шийдвэрлэж хариу өгсөн- 206
3. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн- 11
4. Шийдвэрлэх шатандаа байгаа- 12

Өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн шалтгаан нь бусад байгууллагаас өргөдөл шийдвэрлэхэд шаардлагатай албан тоот, мэдээлэл авах, өргөдөл гомдол гаргасан иргэнтэй холбоо барих боломжгүй шийдвэрлэлт удааширсан зэрэг шалтгаантай байна.

Өргөдөл гомдлыг хэлбэрээр нь ангилбал:
1. Талархал-1 буюу 0.45 %
2. Гомдол-139 буюу 63,7 %
3. Санал-4 буюу 1,83 %
4. Хүсэлт-73 буюу 33,4 %
5. Мэдээлэл-1 буюу 0.45 % байна.

Гомдол нь нийт өргөдөл гомдлын 63,7 хувийг эзэлж байна. Гомдлын ихэнх хувь нь нийгмийн даатгалын байгууллага, байцаагч, албан тушаалтны харилцаа, ёс зүйтэй холбоотой, мөн нийгмийн даатгалын байгууллага утсаа авдаггүй, хүнд сурталтай, сэтгэл ханамжид нийцсэн зөвлөгөө, мэдээлэл өгдөггүй гэсэн агуулгатай байна.

Тус газарт ирүүлсэн 218 өргөдөл гомдол, хүсэлтээс 206 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлт 94,4 хувьтай байгаа нь зорилтод түвшиндээ хүрсэн гэж дүгнэв. Харин 11 өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэнд анхаарч, цаашид зөрчил гаргахгүй ажиллах шаардлагатай.

Нийт өргөдөл гомдлын ихэнх хувийг гомдол эзэлж, мөн иргэд даатгуулагчдаас ирүүлсэн талархал 1 байгаа нь үйл ажиллагаагаа сайжруулах, байцаагч ажилтнуудын харилцаа, ёс зүйд анхаарч ажиллах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ хийснээр гомдлын тоог бууруулах, санал хүсэлт, талархлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан.

**4.3.** Газрын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт болон шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж буй байдалд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Газрын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд 6 хэрэглэгчээр, 3 цэсний 21 төрлийн мэдээлэл байршуулсан байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэл-9
- Хөрөнгө оруулалт-5
- Бусад-7

Үүнээс 20 төрлийн мэдээлэл нь бүрэн шивэгдсэн, 1 мэдээлэл нь хугацаа нь болоогүй тул мэдээлээгүй байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл 100 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдэв.

## ТАВ. БУСАД АЖЛЫНТАЛААР

**5.1.**Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/61 тоот тушаалын дагуу НОК-ийн шуурхай штаб дээр тус газрын 13 байцаагч, албан хаагч иргэдэд QR kод олгох ажиллагаанд оролцож, хамтран ажилласан. НОК-т QR код авахаар хүсэлтээ ирүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн 48618 автомашин эзэмшигчийг регистрийн дугаараар нь тухайн байгууллагадаа ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилладаг эсэхийг нийгмийн даатгалын нэгдсэн лавлагааны програмд үндэслэн хянаж, баталгаажуулан ажилласан бөгөөд тухайн байгууллагад шимтгэл төлдөггүй 998 хүний хүсэлтийг буцаан ажиллав.

**5.2.**Нийслэлийн хэмжээнд “Бүх нийтийн бэлэн байдал” зарласантай холбогдуулан дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч нарын иргэд даатгуулагчдад үзүүлж буй утсан харилцааны үйлчилгээнд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Судалгаа шинжилгээний үр дүнд Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд callpro үйлчилгээг нэвтрүүлж иргэд даатгуулагчдын дуудлагад шуурхай хариулах, гомдол саналыг түргэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлж ажилласан.

**5.3.**Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Тушаалын хэрэгжилт хангаж ажиллах тухай” 5/209 тоот албан бичгийн дагуу Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр авагчдын хувийн хэрэг тоолох ажлыг тус дүүргийн 2020 оны 12 дугаар сарын 31-нийг дуусталх хугацааны нийт 31065 тэтгэвэр авагчдын жагсаалт /массив/-ыг баримтлан хийж гүйцэтгэсэн. Тэтгэврийн хувийн хэрэг тоолсон тухай ажлын тайлан, дүн мэдээг Дээд газарт хугацаанд нь хүргүүлсэн болно.

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР